

ЭРҮҮГИЙН ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТЭД ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ: ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ

Нээлттэй Нийгэм Форум нь Монголын Хуульчдын Холбооны Эрүүгийн эрх зүйн хороотой хамтран “Эрүүгийн хууль тогтоомжийн хэрэгжилт, тулгамдаж буй асуудал” сэдэвт 8 цуврал хэлэлцүүлгийг мөрдөгч, өмгөөлөгч, прокурор, шүүгч, их дээд сургуулийн багш нар, хохирогч хамгааллын чиглэлээр ажилладаг ТББ-ын ажилтан зэрэг нийт 150 орчим мэргэжилтнийг оролцуулан 2018 оны 4-р сарын 20-ны өдрөөс 5-р сарын 22-ны хооронд зохион байгуулсан билээ. Хэлэлцүүлгийн үеэр Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилтэд тулгамдаж буй асуудлыг авч хэлэлцлээ.

Эхний 6 цуврал хэлэлцүүлгийг тодорхой ажил мэргэжлийн хүрээнд хийсэн бол сүүлийн хоёр хэлэлцүүлгийг бүх талын төлөөллийг оролцуулан зохион байгуулснаараа онцлогтой. Үүний дүнд хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой тулгамдаж буй асуудлыг аль болох олон талын оролцоог ханган тодорхойллоо. Хуульчид, хууль сахиулагчдын өмнө тулгарч буй асуудал нь хуулийг нэг мөр хэрэгжүүлэх, асуудлыг шийдвэрлэх оновчтой шийдлийг эрэлхийлэхэд оршиж буй тул гарсан бүхий л санал шүүмжийг нэг бүрчлэн тусгахыг эрмэлзсэн болно. Үүний зэрэгцээ бүх асуудалд бус зарим нэгд зарчмын зөрүүтэй байр суурь, эсхүл тодорхой санал гарсныг тусгасны улмаас бичиглэл, найруулгын хувьд нэг мөр болоогүйд хүлцэл өчье.

Хэлэлцүүлгээс гарсан тулгамдсан асуудлыг нийтлэг болон тусгай асуудлууд хэмээн хоёр бүлгээр танилцуулж байгаа бөгөөд дээрх 4 хуулийн хүрээнд нийтлэг 90, тусгай 266 тулгамдсан асуудлыг тодорхойлоод байна. Энэхүү хуулийн шүүмж нь эрүүгийн хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах, хууль хэрэгжүүлэх албан тушаалтныг чадавхжуулах, хуулийг нэг мөр хэрэгжүүлэх дүрэм журам, удирдамж, заавар зөвлөмж, гарын авлага боловсруулахад хувь нэмэр болно гэдэгт найдаж байна.

Хэлэлцүүлэгт оролцсон хуульчид, хууль сахиулагчид, иргэний нийгмийн ажилтнуудын нэрсийг хавсаргасан болно.

Нэг. Нийтлэг асуудал

- 1.1. Тус хуулийг боловсруулж, батлахдаа Үндсэн хуульд нийцэж байгаа эсэхийг бүрэн судлаагүй, уялдаатай хуулиудтай нь хамт хэлэлцээгүйн улмаас тухайн хууль Үндсэн хуультай зөрчилдөх, бусад салбар хуулиудтай зөрчилдөх, ерөнхий анги нь тусгай ангитайгаа зөрчилдөх асуудал үүсэж байна.

Санал: Хуулийн ерөнхий анги, тусгай анги хоорондын зарчмын зөрүүг арилгах.

- 1.2. Зөрчлийн тухай хуульд гэмт хэргийн шинжтэй зөрчлүүдийг тусгаж, нийгэмд ихээхэн хор уршигтай зөрчилд бага хэмжээний торгуулийн шийтгэл ногдуулсан нь тус хуулийн гол үзэл санаатай зөрчилдөхөд хүргэж байна.

Санал: Гэмт хэргийн шинжтэй зөрчлийг Эрүүгийн хуульд тусгах, цаашлаад Эрүүгийн хууль болон Зөрчлийн тухай хуулийн ялгаа заагийг илүү тодорхой тогтоож, хуульчлах шаардлагатай.

- 1.3. Зөрчлийн тухай хуульд оногдуулж байгаа шийтгэл харьцангуй байна. Ноцтой зөрчлүүд дээр торгуулийн хэмжээ маш бага. Тухайлбал, хуулийн 7.11 дүгээр зүйлийн 2.3-т тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тусгай зөвшөөрлийн талбайгаас хэтрүүлэн үйл ажиллагаа явуулсан бол хүнийг 1 сая төгрөг, хуулийн этгээдийг 10 сая төгрөгөөр торгохоор байна.

- 1.4. Торгуулийн хэмжээг тодорхой интервалтай болгох шаардлагатай. Хуулиар торгуулийн хэмжээг интервалтай тогтоогоогүй нь 1.3-т заасан “...шийтгэл, албадлагын арга хэмжээний төрөл, хэмжээ нь зөрчил үйлдэгдсэн нөхцөл байдал, зөрчлийн шинж, хохирлын хэр хэмжээнд тохирсон байна” гэсэн зарчимтай зөрчилдөж байна. Тухайлбал, мотоциклыг ганцаараа 0.20 хувийн согтолтой жолоодох, автобусыг 45 хүнтэйгээр 5.00 хувийн согтолтой жолоодох зөрчилд адилхан шийтгэл оногдуулж байна.

- 1.5. Зөрчлийн тухай хуулиар зарим зөрчлийн торгуулийн хэмжээ өмнөх хуульд заасан хэмжээнээс харьцангуй ихэссэн нь асуудал үүсгэж байна. Тухайлбал, утаат тамхийг худалдаалах журам зөрчихөд 300 мянган төгрөгөөр торгох шийтгэл ногдуулж байна. Гэтэл тухайн ТҮЦ-ний нэг өдрийн орлого нь 20, 30 мянга хүрэх үү, үгүйтэй байдаг тул орлогыг харгалзан торгууль ногдуулах нь зүйтэй.

- 1.6. Орон нутагт торгуулийн мөнгө нь төсвийн цоорхойг нөхөх зорилгод ашиглагдаж байна.

- 1.7. Мөн хуулийг хэрэглэх явцад хуулийн хэрэглээтэй холбоотой хувь хүн, албан байгууллагад хохирол учирвал хэн, хэрхэн хариуцлага хүлээх талаар зохицуулалт шаардлагатай байна.

- 1.8. Зөрчлийн тухай хуульд шинээр оруулах санал:
- Орчин тойрондоо аюул учруулж болох амьтныг харуул хамгаалалт хараа хяналтгүй байлгаснаас бусдад хөнгөн хохирол, айдас түгшүүр бий болгосныг зөрчилд тооцох
 - Нийгэмд элбэг тохиолддог бусдыг гудамж талбайд байхад нь доромжлох, бие махбодид нь зөвшөөрөлгүй хүрэх, дагах, үг хэлээр доромжлох, сэтгэл санааны хохирол учруулах зэрэг үйлдэлд ямар хариуцлага, хэрхэн хүлээлгэх нь хуульд тодорхой тусгагдаагүй нь эрхээ хамгаалуулах, зөрчигдсэн эрхээ сэргээлгэх боломжийг нь үгүйсгэж, цагдаагийн

байгууллагаас уг тохиолдолд ямар арга хэмжээ авах, хэрхэн зохицуулах тал дээр тодорхойгүй байдал үүсгэж байна.

- Сошиал ертөнц, хэвлэл мэдээллийн хэрэгслээр хүмүүсийн хувийн орон зайд халдах үйлдлийг зөрчилд тооцож, торгууль шийтгэлийг тодорхой зааж оруулах. Тухайлбал, “Нэг хүүхэн араар нь тавьсан нөхрөө явалдсан хүүхэнтэй нь цуг шалдан зургийг нь facebook-д тавьсан. Үүний улмаас нөгөө хүүхэн сэтгэл санааны гүн хямралд ороод амиа хорлосон.”

Санал: Эрүүгийн хуулийн 13.10, 13.11 дүгээр зүйлээр хувь хүний нууцад халдах, нууцыг задруулах гэмт хэргийг хуульчилсан тул Зөрчлийн тухай хуульд оруулах шаардлагагүй.

- 1.9. Зөрчлийн тухай хуульд заасан зарим зөрчил шийдэгдэхгүй байна. Тухайлбал, Гадаа явж байхад хүмүүс нус цэрээ хаях, архи, тамхины зөрчил зэрэгт хууль хэрэгжихгүй байна.
- 1.10. Нийтээр дагаж мөрдөх журмыг (Дугаарын хязгаарлалт, нэгдүгээр эгнээгээр явахгүй байх) зөрчсөн тохиолдолд ямар хариуцлага тооцохыг тодорхой зааж өгөх шаардлагатай. Тухайлбал, шөнийн цэнгээний газрууд цагийн хязгаарлалт хэтрүүлэн ажилласан бол тооцох хариуцлага нь цаасан дээр байхгүй. Иймд цагдаагийн эрх бүхий албан хаагч хуулийг төсөөтэй байдлаар хэрэглэж, арга хэмжээ авахад хүрдэг. Түүнчлэн дугаарын хязгаарлалт, нэгдүгээр эгнээ зэргийн нийтээр дагаж мөрдөх журам зөрчсөн тохиолдолд ямар арга хэмжээ авах талаар хуулийн журам, зохицуулалт байхгүй байна.
- 1.11. Захиргааны хэм хэмжээний актыг ашиглах асуудал тодорхойгүй, эргэлзээтэй байна. Тухайлбал, байгаль орчны хэрэг дээр асуудал үүсч болох юм. Учир нь хүчин төгөлдөр үйлчилж байгаа журмууд хоорондоо зөрчилдөх, эсхүл хоёрдмол утга агуулгатай байх тохиолдолд хууль хэрэглэхэд эргэлзээтэй байдал үүсч байна. Тиймээс хүчин төгөлдөр үйлчилж байгаа журмуудыг хэрхэн ойлгож, хэрэглэхийг зааглан тусгах шаардлагатай.
- 1.12. Нэг зөрчлийг хэдэн ч удаа үйлдсэн ямар ч ялгаагүй болсон. Тухайлбал, хулгайлах гэмт хэргийг хэдэн ч удаа хийсэн хохирлын хэмжээ бага бол шийтгээд л өнгөрнө. Энэ тохиолдолд авах арга хэмжээний тодорхой заалт байхгүй. Амьдралын эх үүсвэр болгож буйтай нь холбогдуулан эрүү үүсгэе гэхэд “хулгайлах зөрчлийг удаа дараа” гэсэн гэмт хэрэг байхгүй тул үүсгэх боломжгүй болж байна. Мөн өөрийн эзэмшлийн байр, газарт биеэ үнэлэхийг зохион байгуулсан, биеэ үнэлэхэд зуучилсан бол хүнийг 100 мянга, хуулийн этгээдийг 1 сая төгрөгөөр торгох бөгөөд энэ зөрчлийг удаа дараа хэдэн удаа байсан ч нэг л шийтгэл ногдуулдаг.
- 1.13. Зөрчил гаргасан этгээдийг баривчлах шийдвэрийг хэрэгжүүлэх нөхцөл, хөрөнгийг нь шийдэж өгөх хэрэгтэй байна. Сумдад баривчлах стандарт хангасан байр байдаггүй, аймгуудад буй зарим баривчлах байр нь стандартын бус. Гэтэл стандартын бус байртай холбоотойгоор, зөрчил үйлдсэн этгээдийн амь нас, эрүүл мэндэд хохирол учирвал хэрхэх нь тодорхойгүй.
- 1.14. Тус хуулийн үндсэн зорилго нь зөрчигдсэн эрхийг сэргээх, зөрчлийг арилгахад чиглэх бус харин зөрчлийн тохиолдлуудад тухай бүр арга хэмжээ (ихэнх тохиолдолд торгох) авахад чиглэж байгаа нь ихээхэн учир дутагдалтай байна. Тухайлбал, Хүнсний аюулгүй байдлын

тухай хуулийг сахиулах тал дээр зөрчил гарахаас сэргийлэх, зөрчлийг арилгах нь үндсэн зорилго атал гарсан зөрчил дээр аж ахуй нэгжийг торгоод өнгөрөхөд чиглэж байна.

- 1.15. Зөрчлийн тухай хуульд хуулийн этгээдэд хариуцлага тооцохоор заасан. Гэтэл зөрчил үйлдэж байгаа төрийн албан хаагч зөндөө байна. Тухайлбал, багш сурагчдаас ямар нэгэн үндэслэлгүйгээр мөнгө нэхэх, архивын бичиг баримтыг журмын дагуу баримтжуулаагүй байх, засаг дарга зөвшөөрөлгүйгээр, давхардуулаад газрын гэрчилгээ олгож байгаа зэрэг зөрчилд төрийн албан хаагчид арга хэмжээ авах, шийтгэл оногдуулах санкц байхгүй байна.
- 1.16. Зөрчлийн тухай хуулийн ерөнхий ангид завдалтын тухай ойлголт ерөнхийдөө байхгүй. Гэтэл зарим зөрчилд завдалтыг тооцох шаардлагатай байна. Тухайлбал, нэг этгээд Бээжингийн галт тэргэнд ноос ноолуур, мах ачаад баригдчихна. Энэ тохиолдолд цагдаагийн байгууллага шалгаад, зараагүй байна гэсэн үндэслэлээр зөрчлийн хэргийг хааж байна. Мөн ойд буу үүрсэн хүмүүсийг гэмт хэрэг, зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх зорилгоор бууг нь хураах гэхээр хууль шийдэхгүй байна.

Санал: Зөрчил үйлдэхээр завдсан тохиолдолд эд зүйлийг хураан авах зохицуулалтыг оруулах нь зүйтэй. Тухайлбал байгаль орчны журмын эсрэг зөрчлүүдэд энэ зохицуулалт шаардлагатай байна.

- 1.17. Байгаль орчны багц хуулиудыг зөрчсөн үйлдэлд оногдуулах шийтгэлийг нэмэх, хариуцлагыг хүндрүүлэх шаардлагатай байна. Эсвэл зарим зүйл заалтыг эрүүгийн хуульд тусгах шаардлагатай.

Хоёр. Тусгай асуудал

- 2.1. Хуулийн 1.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “зөрчил гаргасан этгээдэд шийтгэл оногдуулахын зэрэгцээ зөрчил үйлдэгдэхээс урьдчилан сэргийлэх”-д чиглэсэн байхаар зорилгыг өөрчлөх шаардлагатай байна.
- 2.1. Хуулийн 1.3 дугаар зүйлийн 2 дох хэсэгт зөрчил тус бүрд шийтгэл оногдуулахаар заасан бол 3.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт нэг үйлдэл, эс үйлдэхүй нь энэ хуулийн тусгай ангид заасан хоёр, эсхүл түүнээс дээш зөрчлийн шинжтэй бол аль хүнд шийтгэл оногдуулсан зөрчилд шийтгэл ногдуулахаар заасан нь хоорондоо зөрчилдөж байна.

Тайлбар: Нэг үйлдэл, эс үйлдэхүйгээр хоёр, түүнээс дээш зөрчил гаргасан тул холбогдогчийн эрх зүйн байдлыг дордуулахгүйн тулд аль хүнд шийтгэл оногдуулахаар зааж байгаа нь зөрчилдөж буй ойлголт биш юм.

- 2.2. Хуулийн 1.5 дугаар зүйлд заасан хөөн хэлэлцэх хугацааг тухайн зөрчил гаргасан шалтгаанаас хамааран тодорхой зааж өгөх шаардлагатай. Анх удаа, санамсаргүйгээр зөрчил гаргасан гэх мэт зөрчлийн ялгаа байдаг тул хөөн хэлэлцэх хугацаа нь ялгаатай байх шаардлагатай.

Санал: Зөрчлийг болгоомжгүй, санамсаргүй үйлдэх тухай хууль зүйн ойлголт байхгүй, энэ талаар санаатай болгоомжгүй гэсэн субьектив шинжийг ялган оруулах шаардлагагүй. Мөн зөрчил бол жижиг хэмжээний хэрэг, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилго нь зөрчлийг бууруулахад оршино. Иймд зөрчлийг үйлдсэн санаа зорилгыг ялган зааглах боломжгүй юм.

- 2.3. Хуулийн этгээдийн хөөн хэлэлцэх хугацааг тогтоосон 1.5 дугаар зүйлийн 3 дах хэсэгт тодорхойгүйн улмаас хуулийн этгээдийн хөөн хэлэлцэх хугацаа 5 жилээс 20 жил байхаар буруу ойлгогдохоор байна.

Санал: Торгох шийтгэлийн хэмжээг хуулийн этгээдэд 10 дахин нэмэгдүүлж оногдуулахаар хуульчилсан бөгөөд хөөн хэлэлцэх хугацаа торгуулийн хэмжээнээс хамаарч хуулийн этгээдэд 6 сараас 2 жил байна.

- 2.4. Хуулийн 2.4 дүгээр зүйлд заасан зөрчил үйлдсэн хугацаа, мөн хуулийн 1.5 дугаар зүйлд заасан хөөн хэлэлцэх хугацааг баримталбал зарим зөрчлийн хувьд хөөн хэлэлцэх хугацааг тооцоход хүндрэл учирч байна. Тухайлбал, Зөрчлийн тухай хуулийн 15.24 дүгээр зүйлийн 1-д зааснаар иргэн тогтоосон хугацаанд иргэний улсын бүртгэлд бүртгүүлээгүй 6 сар өнгөрсөн тохиолдолд торгууль оногдуулахгүй болж байна.

- 2.5. Хуулийн 1.5 дугаар зүйлд зөрчлийн шийтгэлгүй байх хугацааг 3-6 хүртэлх сар гэж тодорхой зааж, нэмж оруулах нь зүйтэй. Шийтгэлтэй хугацааг тодорхой болгож өгөхгүй бол тухайн хүний хувийн хэрэгт байнга дагалддаг нь давхар залхаалт болж байна.

Санал: Зөрчлийн шийтгэлгүйд тооцох хугацааг тусгах шаардлагагүй, зөрчлийн тухай хуулийн үзэл баримтлалтай зөрчилдөнө. Зөрчлийг давтан үйлдэх тухай ойлголт хуульд тусаагүй.

- 2.6. Хуулийн 1.5 дугаар зүйлийн 7 дахь хэсэгт Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа эхэлснээр хөөн хэлэлцэх хугацааг тоолохыг зогсооно гэсэн нь өмнөх заалтуудтайгаа зөрчилдөж байна.

Санал: Зөрчлийг шалгаж эхэлснээр хөөн хэлэлцэх хугацаа тоолохыг зогсоох тухай ойлголт нь шударга ёсны зарчимд нийцнэ.

- 2.7. Хуулийн 2.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан “зөрчил” гэсэн тодорхойлолтыг “Хууль, захиргааны хэм хэмжээний акт зөрчсөнийг тогтоосон эрх бүхий албан тушаалтны сануулга, шаардлагыг биелүүлээгүй, энэ хуульд шийтгэл ногдуулахаар заасан үйлдэл, эс үйлдэхүйг зөрчил” гэнэ гэж өөрчлөх.

Санал: Зөрчлийн тухай хуулийн 15.2 дугаар зүйлд төрийн албан тушаалтны шийдвэрийг үл биелүүлэх, үйл ажиллагаанд нь саад учруулахыг зөрчилд тооцохоор зохицуулсан тул засвар оруулах шаардлагагүй.

- 2.8. Хуулийн 2.3 дугаар зүйлд төрийн албан хаагчийн ёс бус, хариуцлагагүй үйл ажиллагаанаас шалтгаалж хүн, хуулийн этгээд зөрчил үйлдсэн бол хариуцлага хүлээлгэхгүй байх асуудлыг нэмж тусгах нь зүйтэй. Ингэснээр төрийн байгууллагын хариуцлага, сахилга батыг сайжруулахад ач холбогдолтой.

Санал: “Төрийн байгууллага, албан тушаалтан албаны чиг үүргээ хэрэгжүүлээгүйгээс үүдэн хүн, хуулийн этгээд зөрчил үйлдсэн бол хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болно” гэж Зөрчлийн тухай хуулийн 2.3 дугаар зүйлд нэмж тусгах

- 2.9. Хуулийн 3.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан “урьдчилан сэргийлэх” гэсэн заалт хэрэгжихгүй байна.

Санал: Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль батлагдах тул үүнийг оруулах шаардлагагүй.
Зөрчлийн тухай хуулийг сурталчлах шаардлагатай.

- 2.10. Хуулийн 3.4 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт заасан торгуулийг хэсэгчлэн төлүүлэх асуудлыг журмаар зохицуулах нь зүйтэй.

Санал: Журмаар зохицуулахаар зааж, журмыг засгийн газар батлахаар зохицуулалт нэмэх

- 2.11. Хуулийн 3.5 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт зарим бүлгийг нэмж тусгах шаардлагатай. Тухайлбал, “ахмад настан” гэж нэмж, насыг нийгмийн даатгал, тэтгэвэр тэтгэмжийн тухай хуультай уялдуулан тогтоох, мөн 1 хүртэлх насны хүүхэдтэй эмэгтэйг баривчлах шийтгэлээс чөлөөлөх тухай ойлголтыг Зөрчлийн тухай хуулийн 3.5 дугаар зүйлд нэмж тусгах шаардлагатай.

- 2.12. Хуулийн 3.5 дугаар зүйлд “баривчлах шийтгэл эдлүүлэхэд саад болохуйц өвчтэй хүнд оногдуулахгүй” гэсэн нь тодорхойгүй бөгөөд шүүх нотлох баримт шаардаад байдаг.

Санал: Ялаас өвчний улмаас чөлөөлөх өвчний жагсаалтаар зохицуулагдаад явах боломжтой тул тусад нь жагсаалт гаргах шаардлагагүй.

- 2.13. Хуулийн 4 дүгээр бүлэгт “Сануулах” шийтгэлийн төрлийг нэмж хуульчлах нь зүйтэй. Нийгэмд үйлдэгдэж байгаа зарим зөрчилд торгох, баривчлах, эрх хасах шийтгэлийг оногдуулахаас илүүтэйгээр анхааруулах, сануулах нь эерэг үр дүнтэй. Сануулах шийтгэл нь мэдээллийн санд орно. Тухайлбал: 5.1 дүгээр зүйл буюу “Олон нийтийн газарт биеэ зүй бусаар авч явах” зөрчилд сануулж болох юм.

Санал: Шийтгэлийн төрөлд “сануулах” шийтгэлийн төрлийг нэмэх боломжгүй, учир нь зөрчил бүрд шийтгэл оногдуулахаар хуульчилсантай холбоотой. Гэвч санал хуваагдсан.

2.14. 4.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт “Хуульд өөрөөр заагаагүй бол энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан хөрөнгө, орлогоос хохирол нөхөн төлөхөд зарцуулж, үлдсэн хэсгийг улсын төсөвт төвлөрүүлнэ” гэсэн нь зөрчилтэй байна.

Санал: Зөрчил үйлдсэнээс үүдэн орж ирж буй хөрөнгө, орлогыг улсын төсөвт төвлөрүүлэх нь зөрчил гаргахгүй байх, урьдчилан сэргийлэх бодлоготой зөрчилдөх тул энэ нь тусгай санд төвлөрч, улмаар хохирол барагдуулах, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлд зарцуулагддаг байх шаардлагатай.

2.15. Зөрчлийн тухай хуулийн 4.2 дугаар зүйлийн 2 дох хэсэгт “үнийг гаргуулах” гэсэн бол Эрүүгийн хуулийн 7.5 дугаар зүйлийн 4 дэх хэсэгтэй харьцуулахад илүүц болжээ.

2.16. Хуульд байгаа зарим заалт тухайлбал, 5.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг (гудамжинд нус цэрээ хаях) хэрэгжих боломжтой талаас нь өөрчлөлт оруулах шаардлагатай.

2.17. Хуулийн 5.2 дугаар зүйлд “Танхайрах” зөрчлийг заахдаа зөвхөн “олон нийтийн газарт” гэж томъёолсон. Үүний улмаас ахуйн хүрээнд танхайрсан зөрчилд хариуцлага тооцох зохицуулалт орхигдсон. Цагдаагийн байгууллагад 5.3, 5.4-т зааснаас бусад байдлаар бусдын амгалан тайван байдлыг алдагдуулах төрлийн зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл ихээр бүртгэгдэж байна.

Санал: Зөрчлийн тухай хуулийн 5.2 дугаар зүйлд “бусад” гэсэн нэмэлт оруулах нь зүйтэй.

2.18. Хуулийн 5.3 дугаар зүйлд хүний биед хохирол учруулахгүйгээр халдаж зодох гэсэн нь ойлгомжгүй байна.

Тайлбар: Хүний биед хөнгөн, хүндэвтэр, хүнд хохирол учруулах тухай ойлголтыг эрүүгийн хуулийн тусгай ангид заасан, иймд дээрх хохирлоос бусад гэмтэл, шарх, сорви учруулсан үйлдэлд зөрчлийн тухай хуулиар хариуцлага хүлээлгэнэ.

2.19. Гэр бүлийн хүчирхийлэл буюу 5.4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсэгт заасан “хүсэл зоригийнх нь эсрэг тодорхой үйлдэл хийх, хийхгүй байхыг албадсан” гэсэн нь тодорхойгүй байна. Үүний улмаас энэ үйлдлийг нотолж чадахгүй, яаж нотлох нь тодорхойгүй байгаагаас их олон зөрчил хэрэгсэхгүй болж байна. Мөн 5.4 дүгээр зүйлийн 4.3, 4.4 дэх хэсэгт заасан “бусадтай харилцахыг хязгаарласан”, “хуваарьт болон дундын эд хөрөнгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхэд халдсан” гэснийг тайлбарлах шаардлагатай.

2.20. Гэр бүлийн хүчирхийлэгч гэр хороололд амьдардаг, 7 хоногт 7 удаа ар гэртээ “агсам” тавьсан тохиолдолд, эсхүл орон сууцанд амьдардаг энэ үйлдлээ өдрийн цагаар үйлддэг бол тухайн хүнд хуулиар хариуцлага хүлээлгэх ямар ч боломж, механизм байхгүй байна. Тухайлбал, гэр хороололд амьдардаг, шоронгоос суллагдсан эр шөнөөр эхнэр рүүгээ муухай харж суугаад, шөнөжин хутга хурцалсан.

2.21. Хуулийн 5.4 дүгээр зүйлийн тайлбарын найруулгыг эргэж харах шаардлагатай. Тус тайлбараар зөвхөн захиргааны хэм хэмжээний актыг зөрчихийг ойлгохоор байна.

2.22. Хуулийн 5.4-дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт “торгуулийн шийтгэл” оногдуулах санкц бий болгох. Албадан сургалтыг баривчлах шийтгэлтэй хамт хэрэглэж байгаа нь оновчтой эсэх.

Тайлбар: Баривчлах шийтгэл нь оновчтой зохицуулалт бөгөөд уг зөрчил нь цаашдаа хүнд гэмт хэрэг гарах суурь үндэс болдог учир торгох шийтгэлээр солих нь үндэслэлгүй. Мөн баривчлах шийтгэлийг албадан сургалттай хамтатган хэрэгжүүлэх нь хүчирхийлэл үйлдэгч зан үйлээ засахад оновчтой шийтгэл юм.

2.23. Хуулийн 5.4 дүгээр зүйлд заасан “гэр бүлийн хамааралтай хүн” гэдэг нэр томъёог тодорхой болгох шаардлагатай байна. Практикт албан ёсоор гэрлэлт цуцалсан хүнийг гэр бүлийн хамааралтай хүн гэж үзэх тохиолдол байна.

2.24. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн анх удаагийн болон удаа дараагийн үйлдэлд шийтгэл ижил байгаа нь учир дутагдалтай байна. Анх удаагийн тохиолдлоос үүдэн харилцаа нь муудаж, эцэст нь салах шийдвэрт хүрч байгааг анхаарах нь зүйтэй.

2.25. Хуулийн 5.5-д “Нийтийн зориулалттай орон сууцны оршин суугчдын амгалан тайван байдлыг алдагдуулах” гэсэн нь гэр хороололд хамаарахгүй байна.

Санал: “Нийтийн зориулалттай” гэсэн үгийг хасах шаардлагатай. Эсхүл “Танхайрах” зөрчил дээр “бусад газарт” гэсэн ойлголтыг тусгавал үүнийг хасах шаардлагагүй юм.

2.26. Хуулийн 5.7-д заасан мөрийтэй тоглоом зохион байгуулах гэсэн хэсэгт “Мөрийтэй тоглоомонд ашигласан эд зүйл, хөрөнгө орлогыг хураах” гэж нэмэх, “олон нийтийн газар” гэснийг шаардлагатай байна.

Санал: Албадлагын арга хэмжээг нэмж оруулах нь зүйтэй. Харин “олон нийтийн газар” гэснийг хасах шаардлагагүй.

2.27. Хог хаягдлын тухай хууль зөрчих зөрчилд хамаарах 6.1 дүгээр зүйлийн 3 дах хэсэгт “усан сан” гэж нэмэх шаардлагатай.

2.28. Хуулийн 6.7 дугаар зүйлийн 7, 8 дах хэсэгт заасан “үр хөндөлт”-ийн асуудалд “эмийн үр хөндөлт”-ийг дэлгэрүүлж хуульчлах шаардлагатай байна. Тэгэхгүй бол их олон охид бүсгүйчүүд амар хялбар, үнэ өртөг багатайг бодож маш хүчтэй үр хөндөх эм ууснаар биеэ хордуулж байна. Зах дээгүүр Хятад улсаас орж ирсэн үр хөндөлтийн эмийг янз бүрээр зарж борлуулдаг.

Санал: Эмийн үр хөндөлтийн асуудлыг нэмж тусгах шаардлагагүй. Хуулийн 6.6 дугаар зүйлд эмийн хууль бус худалдааг зохицуулсан байна.

2.29. Хуулийн 6.10 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт “донорын эд, эрхтнийг худалдан авах, эсхүл худалдан борлуулахаар сурталчилсан бол” гэсэн нь хүн худалдаалах гэмт хэргийн нэг төрөл байтал зөрчилд тооцож байгаа нь буруу юм.

Санал: Зөрчлийн хуулиас хасаж, Эрүүгийн хуульд тусгах шаардлагатай.

- 2.30. Хуулийн 6.18 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт биеэ үнэлсэн, биеийг үнэлсэн гэсэн хоёр этгээдэд хариуцлага тооцохоор заасан бөгөөд биеэ үнэлсэн этгээд олсон орлогоо хураалгахын зэрэгцээ торгуулийн шийтгэл хүлээдэг тул хүлээх хариуцлага илүү өндөр байна. Үүнээс үүдэн биеэ үнэлэгчид гэмт хэргийн хохирогч болсон ч энэ тухайгаа дарагдуулах нь түгээмэл байна. Тухайлбал, буудалд ганцаараа байна гэж дуудчихаад олуулаа нийлж хүчирхийлдэг. Энэ тохиолдолд биеэ үнэлэгч бүсгүй эргээд цагдаад хандаж чаддаггүй.
- 2.31. Хуулийн 6.18 дугаар зүйлийн 7 дах хэсэгт “өөрийн эзэмшлийн байр, газарт биеэ үнэлэхийг зохион байгуулсан, биеэ үнэлэхэд зуучилсан бол хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно” гэсэн зөрчилд хүлээлгэх хариуцлага маш бага бөгөөд бэлгийн мөлжлөг буюу хүн худалдаалах гэмт хэргийн нэг төрлийг зөрчилд оруулж, гэмт этгээдэд ял завших боломж олгож байна. Одоогийн байдлаар энэ зөрчлийг хэдэн ч удаа гаргасан торгуулиад л өнгөрөхөөр байна.

Санал: Энэ зөрчлийг Зөрчлийн тухай хуулиас хасаж, Эрүүгийн хуульд нэмж тусгах.

- 2.32. Хуулийн 6.20 дугаар зүйлийн 1.1, 1.2 дох хэсэгт “хүүхдийг хувцас, хоол хүнс, орон байраар зориуд гачигдуулсан”, “шаардлагад нийцээгүй хоол хүнсний зүйл хэрэглүүлсэн” гэдгийг хэрхэн нотлох нь тодорхойгүй.
- 2.33. Хуулийн 6.20 дугаар зүйлийн 5 дах хэсэгт “сургууль, сургуулийн дотуур байр, тэдгээрийн гаднах орчинд сурагч бусад сурагчийг дарамталж, зүй бусаар харьцаж сургуульд суралцах боломжгүй байдлыг бий болгосон” зөрчилд сургуулийн захиргааг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно гэсэн нь учир дутагдалтай байна. Сургууль өөрөө төрийн өмчит байгууллага тул торгуулийг төсвөөс гаргахгүйгээр, албан тушаалтан, тухайлбал, сургуулийн захирал төлөхөөр заалтыг өөрчлөх шаардлагатай.
- 2.34. Хуулийн 6.20 дугаар зүйлд судалгааны үндсэн дээр хүүхдийн эрхийн зөрчлийг нэмж тусгах шаардлагатай байна. Тухайлбал, хүүхдийг эцэг эх, хууль ёсны асран хамгаалагч, харгалзан дэмжигч богино болон урт хугацаагаар орхиж явахдаа асран хамгаалах, харгалзан дэмжих хүн тогтоогоогүй бол торгох саналтай байна. Хөдөө орон нутагт ялангуяа хүүхэд, хүүхдээ харан бие дааж амьдарч буй тохиолдол ихээр гарч байгаа бөгөөд энэ үедээ гэмт хэрэгт холбогдох, гэмт хэргийн хохирогч болох зэргээр эрх ашиг нь хохирох нь түгээмэл байна.
- 2.35. Хуулийн 6.21 дүгээр зүйлд туссан “гүтгэх” зөрчилд утсаар дарамтлаад, доромжлоод, ална гээд сүрдүүлээд байгааг шийдэж чадахгүй, татгалзаж байна. “Мэдээллийг нийтэд дэлгэсэн” гэснээс “нийтэд” гэдэг үгийг хасчихвал асуудал шийдэгдэнэ.

Санал: Нийтэд гэдгийг хасах шаардлагагүй, харин энэ зөрчлийг Эрүүгийн хуульд тусгаж, хариуцлага хүлээлгэдэг болох, хэрэв зөрчил гэж үзэж шийдэх боломжтой гэж хууль тогтоогч үзвэл тусгай журмаар шалгах зөрчлөөр шалган шийдвэрлэхээр зохицуулах.

- 2.36. Хуулийн 6.22 дугаар зүйлд зөвхөн орон байр гэж хязгаарласныг дэлгэрүүлэх шаардлагатай. Зөвшөөрөлгүйгээр гэрэл зураг авах, дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэг хийхийг зөвхөн орон байр гэж хязгаарлах нь зохимжгүй бөгөөд хүний халдашгүй байдалд хамаарах асуудал тул энэ заалтыг дэлгэрүүлэх шаардлагатай.

Тайлбар: Хүний зургийг зөвшөөрөлгүй авах үйлдлийг зөрчилд тооцвол түүнийг шалган шийдвэрлэх байгууллагын ачаалал нэмэгдэнэ, хэрэв тухайн иргэний зургийг аваад гутаан доромжилсон сэтгэгдэл бичих, цааш түгээсэн бол гүтгэх зөрчлөөр шийдвэрлэх боломжтой тул хуульд нэмэлт оруулах шаардлагагүй.

- 2.37. Байгаль орчны зөрчил нь 20-30,000 нэгжээр торгуулахаар байна. Энэ нь учруулсан хохиролтой нь харьцуулахад бодит шийтгэл болохооргүй юм. Байгаль орчны журмын эсрэг гэмт хэргийн шинжтэй үйлдлийг зөрчил болгосон нь асуудал үүсгэхээр байна. Тухайлбал, зөвшөөрөлгүй цэгт хаягдал усыг хэдий хэмжээгээр нийлүүлсэн эсэхээс үл хамааран хүнийг 1 сая, хуулийн этгээдийг 10 сая төгрөгөөр торгохоор байгаа нь учир дутагдалтай.
- 2.38. Амьтны тухай хууль зөрчсөн зөрчилд холбогдох 7.6 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт “худалдсан, худалдан авсан, тээвэрлэсэн, хадгалсан”, Ойн тухай хууль зөрчсөн зөрчилд хамаарах 7.9 дүгээр зүйлийн 6 дах хэсэгт “хууль бусаар бэлтгэснийг хураах” гэсэн үйлдлүүдийг нэмэх шаардлагатай.
- 2.39. Хуулийн 8.6 дугаар зүйл буюу “Хулгайлах” тухай заалтыг Зөрчлийн хуулиас хасаж, Эрүүгийн хуульд оруулах шаардлагатай. Хулгайлах үйлдэл нь үйлдлийн арга сэдэлт, санаа зорилго, бүх шинжээрээ гэмт хэргийн шинжийг агуулж байгаа тул хулгайн үйлдэл дээр хохирлын хэмжээгээр ялгадаг байдлыг арилгах нь зүйтэй.
- 2.40. Тус хуулийн 9.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт “багшийг ажил үүргээ гүйцэтгэхэд нь зориуд саад учруулсан бол хүнийг хорин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно” гэж заасныг хэрхэн ашиглах, ойлгох тал дээр тодорхойгүй байдал үүсэж байна. Иймд уг заалтыг тодруулах шаардлагатай.
- 2.41. Хуулийн 9.10 дугаар зүйлийн 2.4 дэх хэсэгт “төрийн албан ёсны хэлээр гарч байгаа олон нийтэд зориулсан хэвлэл, мэдээлэл нь орчин цагийн монгол утга зохиолын хэлний хэм хэмжээ, нэр томъёог баримтлах тухай журам зөрчсөн бол хүнийг нэг зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно” гэснээс “хүнийг нэг зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно” гэснийг хасах саналтай байна.
- 2.42. Хуулийн 10.4 дүгээр зүйлийн 1 дэх заалтад “Зөвшөөрөлтэйгөөр эрхлэх худалдаа, үйлдвэрлэл үйлчилгээг зөвшөөрөлгүйгээр явуулсан бол хувь хүнийг 50 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг 500 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно” гэсэн нь үйл ажиллагаа, ашиг орлогоос хамаарахгүй байгаа тул хүлээх хариуцлага сул байна. Тухайлбал, цахим тоглоомын газрыг хэдэн өдөр ажиллуулж, хэдэн төгрөг олсон эсэхээс үл хамааран 50 нэгжээр л торгохоор байна.

- 2.43. Хуулийн 10.13 дугаар зүйлийн 5.2 дах хэсэгт гэмт хэргийн шинжтэй үйлдэл буюу хар тамхи, мансууруулах бодис үйлдвэрлэх, борлуулах зэрэг олон улсын хэмжээнд хориглосон ажилд зуучилсан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол зөрчилд тооцохоор заажээ. Эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй хар тамхи, мансууруулах бодис үйлдвэрлэх гэж байхгүй ш дээ. Мөн хүүхдээр тэвчишгүй хөдөлмөр эрхлүүлэх асуудлыг зөрчилд тусгасан.
- 2.44. Хуулийн 10.14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт жуулчны үйлчилгээний байгууллага хуульд заасан үйл ажиллагаа явуулах нь зөрчилд тооцогдохоор байгаа алдааг залруулах шаардлагатай.
- 2.45. Нийгмийн даатгалын тухай хууль зөрчих тухай 10.17-р зүйлд “тайлан мэдээ хоцроосон” гэдэг хамгийн нийтлэг зөрчил тусаагүй. Мөн энэ зөрчлийн хөөн хэлэлцэх хугацаа 6 сар бөгөөд дууссан бол актаар арга хэмжээ авч, нийгмийн даатгалын хуулиараа 250,000 төгрөгөөр торгож байна. Үүний зэрэгцээ энэ зөрчилд мэргэжлийн хяналтын байцаагч 2000 нэгжээр торгоод болохоор байгаа НДШ нь төлөгдөөгүй ажилтны эрх ашиг хохироход хүрэхээр байна. Үүний улмаас нийгмийн даатгалын байгууллага шууд акт тавиад, зөрчлийг шийдэхээ болих хандлага ажиглагдаж байна. Энэ нь эрх зүйн дээрдүүлсэн хувилбар гэж үзэхээр байна.
- 2.46. Хуулийн 11.7 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “ТББ-ын орлогоос ногдол ашиг хуваарилсан, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын төлбөрийг төлсөн бол хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж хүнийг тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно” гэсэн нь ойлгомжгүй байна. Орлого олох арга замын тухай дурдаагүй байж, “хууль бус” орлогыг хураана гэсэн нь тодорхойгүй байдлыг бий болгож байна.
- 2.47. Хуулийн 13.5 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэгт “гарал үүслийн гэрчилгээгүй мал, мах худалдаалсан” зөрчлийг орхигдуулсан тул нэмж тусгах шаардлагатай.
- 2.48. Хуулийн 14.4 дүгээр зүйлийн 2.4-дэх заалт буюу “авто зам, замын байгууламжийн техник ашиглалтын үзүүлэлтээс хэтэрсэн овор, даацтай тээврийн хэрэгслээр авто замаар зорчсон бол” хүнийг 150000, хуулийн этгээдийг 1500000 төгрөгөөр торгохоор байна. Гэтэл орчин үеийн тээврийн хэрэгсэл 50-100 тонн даацтай байхад авто зам, замын байгууламжийн даацын стандарт хоцрогдсон нь зөрчил үүсгэж байна. Учир нь хүнд даацын тээврийн хэрэгслийг нэгэнт хилээр оруулж, тээвэр хийх зөвшөөрлийг олгочоод зөрчил гаргаж байна гэж торгууль ногдуулаад байгаа нь учир дутагдалтай юм.

Хуульчид

1. П.Адьяасүрэн
2. Ц. Алдархишиг
3. С.Алминцэцэг
4. Ц.Алтангадас
5. Т.Алтантуяа
6. Н.Анхбаяр
7. Ч.Анхбаяр
8. Н.Арвинтариа
9. А.Ариунзаяа
10. Н.Баасанбат
11. Ц.Баасандэлгэр
12. А.Баатар
13. Д.Бадам
14. С.Байгалмаа
15. А.Бакыт
16. Д.Батгэрэл
17. А.Батгэрэл
18. Б.Батзориг
19. Г.Батнасан
20. Б.Бат-Орших
21. Д.Батсүх
22. П.Баттулга
23. Ж.Бат-Эрдэнэ
24. М.Баярсайхан
25. Д.Баярсүрэн
26. Б.Баярхүү
27. Т.Баясгалан
28. Ч.Болдбаатар
29. Д.Болдсайхан
30. Г.Болормаа
31. Д.Бурмаа
32. Г.Бямбадорж
33. Б.Галсанжамц
34. Б.Ганбаатар
35. Т.Ганбат
36. Б.Ганболд
37. В.Ганболд
38. А.Ганзориг
39. М.Гансүвд
40. С.Гансэлэм
41. Б.Гантулга
42. Б.Гэрэлмаа
43. Ц.Дайрийжав
44. С.Дангаасүрэн
45. Б.Дашдондов
46. Д.Дашцэрмаа
47. Г.Должинсүрэн
48. Б.Дуламсүрэн
49. Ш.Ербол
50. Б.Жавхланбаяр
51. Ч.Жадамба
52. У.Жамбацэрэн
53. Б.Жаргал
54. Ч.Жаргалбаатар
55. И.Золзаяа
56. М.Лхагвасүрэн
57. Б.Мангилик
58. Б.Манлайбаатар
59. Н.Манлайбаатар
60. Т.Мөнхбадрах
61. Т.Мөнхдалай
62. Т.Мөнх-Оргил
63. Ц.Мөнхчимэг
64. Ц.Мөнх-Эрдэнэ
65. Г.Наранбаатар
66. Т.Наранбат
67. Х.Наранзул
68. П.Нарантуяа
69. С.Номынбаясгалан
70. Э.Нэмэхжаргал
71. Э.Нямбилэгт
72. Х.Одбаяр
73. Н.Онон
74. Б.Отгон
75. Ч.Отгонсүрэн
76. В.Отгончимэг
77. Ц.Оч
78. М.Очирбат
79. С.Оюун
80. Д.Оюунбат
81. П.Оюунтунгалаг
82. Б.Оюунцэцэг
83. Г.Оюунцэцэг
84. П.Өлзийбаяр
85. М.Өлзийцэцэг
86. С.Өмирбек
87. У.Содбаяр
88. Б.Соёл-Эрдэнэ
89. Д.Сүнжид
90. Б.Сүрмандах
91. Ж.Тамир
92. М.Төрмөнх
93. Я.Туул
94. Ч.Түвшинжаргал
95. Т.Урангэрэл
96. Б.Уранцэцэг
97. Б.Уранчимэг
98. Ц.Уртнасан
99. Г.Халиунаа
100. Б.Хандмаа
101. Л.Хаш
102. В.Хосбаяр
103. З.Хүрэлбагана
104. Г.Цацрал
105. Б.Цогтбаатар
106. Д.Цэндсүрэн
107. С.Цэрэндорж
108. С.Цэцэгмаа
109. С.Цэцэгсүрэн
110. Х.Чекара
111. И.Чимэдбадам
112. М.Чинбат
113. Д.Чинзориг
114. М.Чинзориг
115. О.Чулуунцэцэг
116. Б.Энхбат
117. С.Энхбат
118. Ц.Энхбаяр
119. Д.Энхболд
120. Н.Энхжаргал
121. С.Энхзаяа
122. С.Энхмаа
123. Ж.Энх-Од
124. Л.Энхсайхан
125. З.Энхтайван
126. Ж.Энхтуяа
127. Н.Энхтуяа
128. Х.Эрдэм-Ундрах
129. Г.Эрдэнэбат
130. Б.Эрдэнэ-Очир
131. М.Эрдэнэсайхан
132. Э.Эрдэнэсувд
133. Л.Эрхзаяа

Төрийн бус байгууллагын ажилтнууд

134. А.Балдангомбо
135. Б.Баттогтох
136. Б.Баярмаа
137. Б.Баярмаа
138. Г.Ганбаясгах
139. Б.Жавзанхүү
140. Д.Мягмардорж
141. Б.Онон
142. Ч.Сэмжидмаа
143. Т.Цогзолмаа
144. П.Цэвээн
145. С.Цэндбаатар

Дугаарыг эрхэлсэн: **Б.ХИШИГСАЙХАН**
ННФ-ын Засаглалын хөтөлбөрийн менежер

Хаяг: Жамъян гүний гудамж - 5/1
Сүхбаатар дүүрэг,
Улаанбаатар - 14240
Монгол Улс

Утас: 976-11-313207
Факс: 976-11-324857
Вэб: www.forum.mn
И-мэйл: osf@forum.mn

Хамтрагч байгууллага:



МОНГОЛЫН ХУУЛЬЧДЫН ХОЛБОО
Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Их
эзэн Чингис хааны нэрэмжит талбай-7, Хууль зүйн
үндэсний хүрээлэнгийн 4 давхар, 403 тоот
Утас: 70116007, 70116065
И-мэйл: info@mgfbar.mn